



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 19 өдөр

Дугаар 4/122

Булган сум



Хэлэлцүүлэг зохион байгуулах тухай



Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.7, 18.2 дахь заалт, аймгийн ИТХ-ын 2024 оны IV Хуралдааны 25 дугаар тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2024-2028 оны “Булганы сэргэлт” үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.5.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 82 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг Булган аймагт ажиллаж, бичил, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих тогтолцоог оновчтой болгох чиглэлээр санал, дүгнэлт гаргах холбогдох хуулийн төсөл боловсруулж, тулгамдаж буй асуудал шинэ тутам үүсэж буй эрх зүйн харилцаа, түүний зохицуулалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, сайжруулах талаар төр, төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагуудтай зохион байгуулах уулзалт хэлэлцүүлгийн хөтөлбөрийг 1 дүгээр, шаардлагатай хөрөнгийн зардлыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Уулзалт, хэлэлцүүлэгт төрийн болон төрийн бус байгууллага, бизнес эрхлэгчдийг өргөн хүрээтэй оролцуулж, санал хүсэлтийг нь сонсохыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст (Г.Давааням)-д даалгасугай.

4. Шаардлагатай 2,183,000 (хоёр сая нэг зуун наян гурав мянга) төгрөгийг “Үйлдвэрлэлийн сэргэлт”-ийн бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР




Аймгийн Засаг даргын 2025 - оны 02 сарын 19 өдрийн
 4/102 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн хэрэгжилт, хуулийн шинэчилсэн төслийн танилцуулга, бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих тогтолцоог оновчтой болгох, санал авах уулзалт хэлэлцүүлгийн хөтөлбөр

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Илтгэгч, чиглүүлэгч
	2025 оны 02 дугаар сарын 19-ны өдөр (Лхагва гариг) Булган аймаг АЗДТГ- 107 тоот танхим.		
1	Бүртгэл	14.00-14.30	ХХААГ, СХХ
2	Нээлтийн үг (Ажлын хэсгийн бүрэлдэхүүний танилцуулга)	14.00-14.30	Хөтлөгч: Г.Давааням (Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)
3	Булган аймгийн жижиг, дунд үйлдвэр үйлчилгээний салбарын өнөөгийн байдал, цаашид анхаарах асуудал	14:30-14:45	Илтгэгч: Булган аймгийн Засаг даргын орлогч О.Ундрах
4	Уулзалт хэлэлцүүлэг нээлийн үг	14:45-15:00	УИХ-ын гишүүн Д.Батлут үг хэлнэ
5	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн, жижиг, дунд үйлдвэр хоршооны бодлого, чиглэл	15:00-15:40	Илтгэгч: Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны Ахлах шинжээч Э.Сугарбаяр
6	Жижиг, дунд үйлдвэр үйлчилгээ хоршооны салбарт хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар	15:40-16:20	Илтгэгч: Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг, дунд үйлдвэрийн газрын Зээл төслийн хэлтсийн дарга Н.Энхтөр
7	Цайны завсарлага	16:20-16:30	
8	Хуулийн төслийн танилцуулга, Хэлэлцүүлэг	16:30-17:40	Илтгэгч: УИХ-ын гишүүн Дамбын Батлут гишүүний хуулийн зөвлөх Г.Номин
9	Дурсгалын зураг	17:50	
10	Оройн хоол	17.50-18.20	
	Хөвсгөл аймаг явна.		

Аймгийн Засаг даргын 2025 оны 02 сарын 19 өдрийн
4-р дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн уулзалт,
хэлэлцүүлгийн зардлын задаргаа

№	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /төг/	Нийт үнэ
1	Үдийн цайны завсарлага	170	8,500	1,445,000
2	Зутан шөл	18	16,000	288,000
3	Үхрийн жигнэсэн мах	18	25,000	450,000
Нийт				2,183,000